

Д.НОРОВЫН “МӨНХИЙН ДУУДЛАГА” ТУУЖИЙНДҮРИЙН УЯНГА СЭТГЭЛЗҮЙН ХЭВ ШИНЖИЙН АСУУДАЛД

Р. Алтансайхан *

Төрийн шагналт зохиолч Д.Норов 1980-аад оны эхээр хэд хэдэн тууж бичсэний нэг нь “Мөнхийн дуудлага” (1983) тууж юм. Эл тууждаа хүнлэг чанар, ёс суртахуун, эмэгтэй хүний элдэв явдлыг бус голлон тэсвэр хатуужилт зан чанарыг уран сайхны аргаар нээснээс Хишгээ, Дэлэг, түүнийэх, мөн охин, Базар, Даш нарын хэд хэдэн уран дүрээс онцлон сонгож зохиолын гол баатар өнчин охины дүрийн зан төрх, сэтгэл зүй, уран сайхны шийдлийн өвөрмөц онцлог талыг нээх зорилго тавьсан юм.

2004 онд Монгол Улсын Төрийн шагнал хүртсэн Д.Норовын туужуудын нэг болох “Мөнхийн дуудлага” нэрт сэтгэл зүйн хэв шинж бүхий туужийн тухай профессор Д.Галбаатар “...Эл тууж нь уран сэтгэлэг, өвөрмөц зохиомж, баатруудын сэтгэл зүй рүү гүн өнгийсөн эрэл, өрнөж буй хэрэг явдлыг шийдэж тайлсан арга барилаараа онцгой ялгарч байлаа”¹ гэж тодорхойлсон юм. Утга зохиол судлаач, доктор С.Байгалсайхан “Мөнхийн дуудлага” тууж бол зохиомж, өгүүлэмжийн хувьд арай өөр бөгөөд зохиолчийн голлон бичдэг болзолт дүр дүрсэлгээнээс ангид, ахуйн бодит тал руу илтэд хандсан, хүний амьдралын бодит ертөнц, дотоод ертөнц рүү өнгийсөн, сэтгэлийн утсыг хөндсөн зохиол...”² хэмээн үнэлжээ.

Зохиолч Д.Норовын туурвисан эл тууж олны анхаарал татсан даацтай сайн бүтээл болох талаар цөөнгүй судлаач, шүүмжлэгчид сайшаан тэмдэглээд зогссонгүй, түүнийг “Монголын орчин үеийн уран зохиолын түүх, IY боть /1980-2000/”³ бүтээлд XX зууны монгол туужийн төрөл зүйлийн голлох төлөөлөгчдийн нэгээр сонгон оруулсан нь түүний уран бүтээлийн чанар чансаа, зохиолчийн ур чадвар, уран бүтээлчийн байр суурь, эзлэх байр суурийг илтгэсэн хэрэг билээ. Дээрх туужийн тухай “...дайны хор урхаг гэхээсээ илүүтэй хүн чанар, хүнлэг сэтгэл, монгол хүний ёс суртахууны асуудлыг хөндөж дэвшүүлсэн юм”⁴ гэж үнэлсэн байна.

Олонх судлаач-шүүмжлэгчид уг туужийн дүрийг сэтгэлзүй, хүний дотоод ертөнцийн амьдралыг нээн өгүүлсэн гэх зэргээр олонтаа тэмдэглэсэн боловч сэтгэлзүйн

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Утга зохиолын тэнхим

¹ “Монголын уран зохиолын дээжис”, 2007, Улаанбаатар, 11-12-р тал.

² Байгалсайхан С. (2014), “XX зуун тууж судлал”, Улаанбаатар, 216-р тал.

³ “Монголын орчин үеийн уран зохиолын түүх, IY боть”, 2014, ШУС, ХЗХ.

⁴ Байгалсайхан С нар (2014), “Монголын орчин үеийн уран зохиолын түүх, IY боть /1980-2000/”, ШУА, ХЗХ, Улаанбаатар, 176-р тал.

тууж гэх онцлог шинжийн үндэслэлийг томъёолон тогтоосон задлан шинжилгээний ухаалаг даацтай дүгнэлтүүд илт үгүйлэгдсээр байна. “Мөнхийн дуудлага” тууж бол зохиомжийн хувьд өвөрмөц төдийгүй гол дүр Дэлэгийн охин эхээсээ хагацан өнчирч хоёр сар болсон хийгээд энэ үед дайнд явсан эцэг нь дайн дууссан боловч удтал сураг ажиггүй байснаа нэг л өдөр гэр орондоо шинэ эхнэр дагуулсаар эгэн ирсэн үйл явдлууд хийгээд өнгөрсөн зургаан жилийн туршид Хишгээ, хадам ээж, балчир охин, гэр орон, мал ахуйгаа хэрхэн харж хандсан, гадаа гарч эр, дотор орж эм болсон бүсгүй хүний төөрөг тавилан хийгээд эр нөхрийг нь цэрэгт явсан хойгуур эзгүйчлэх Даш, Базар нарын алиг шалиг явдлууд, хадам ээж, бэр хоёрын харилцааны зөрчилдөөн, хүчин буурай, гэр толгойлсон бүсгүй хүний зовлон жаргал хийгээд амьдрал ахуйд тулгарах хэрэг явдлуудыг уран сайхны аргаар хурц зөрчилдөөн дунд нээн харуулсан бөгөөд эцэс сүүлд нь эгэн ирсэн эцэгтээ охин нь ээжийхээ нас барахаасаа өмнө захиас болгосон “Мөн ч их хүлээсэн дээ” гэх аргаа барсан зөвтгөл үгийг дамжуулсан, түүнээс үүдсэн нийгмийн олон эмзэг асуудлыг хам цогцоор нь шийдэж уншигчдын сэтгэл зүрхийг уяраасан бүтээлийн нэг юм.

“Уран дүрийн хэв маяг, шинж байдлыг түүний илрэх цаг хугацааны зайтай холбон үзвэл зохино”⁵ гэсэн онол ёсоор үзэхүл зургаан жил үргэлжилсэн нэгэн гэр бүлийн хэрэг явдлыг онцгой нөхцөл байдалд, цаг хугацааны дэс дарааллыг дагуулан нурших бус, наснаасаа хэтэрсэн ажил үйл гүйцэтгэж, эхдээ хань болсон энхрий бяцхан охиноос орчлонгийн аяг араншингийн жамаар “өнчин охин” болж хувирсан уран дүрийн төөрөг тавиланг нээн харуулсан төдийгүй уран сайхны дүрийн нийгэмд гүйцэтгэдэг хамгийн чухал үүрэг буюу ёс суртахуун, хүний жудаг ёсон, уугал мөн чанарын тухай нээн харуулсан нь уншигчдын эрэл хэрэгцээг хангаж чадсан билээ. “Мөнхийн дуудлага” тууж бол хэдий хэдий нэгэн гэр бүлийн суурь дээр зан суртахуун, орчлонгийн аяг араншингийн ээдрээ эгэл гэр бүлд тохиолдож буй дээрх гунигт хэрэг явдлаар нээн өгүүлсэн ч уншигчийг сэтгэл зүрхийг шимшрүүлэх, уяраах, уйлуулах, ухааруулах /уярах, уйлах гэдэг нь угаасаа оюун санааны нэгэн чухаг таашаал юм/ нь өвөрмөц мэдрэмжийг уншигчдад өгөхөд оршдог.

Сэтгэц бол ухамсар оюун санаа үл оролцох өвөрмөц хүчин зүйлд захирагддаг гэж психоанализ тайлбарладаг бол тэрхүү хүчин зүйлсийн нэг онцгой хурц хэлбэр нь “айдас” юм. Зохиолч жаал охины сэтгэлзүйн дотоод тэмцлийг сонирхолтой, гүн гүнзгий нээсэн байна. Дөнгөж орчлонг таньж ядан, ухаарах насандаа яваа балчир охины сэтгэлийн гүн дэх уй гашууг: “*Ээж ирэхгүй, дахиж олдохгүй, өөр хэнээр ч орлуулж болохгүй гэдгийг охин мэдэрч байлаа. Үүнийг мэдэхийн хамт охины сэтгэлд тэвчиж боломгүй гашуудал дүүрнэ. Ээжгүй байж яагаад ч боломгүй санагдана. Одоо яанам билээ дээ*” хэмээх шаналан, уй гашуу нь даамжирсаар **айдас** болж **айдсаас** үүдэлтэй сэтгэцийн орон зайд хачин гэмээр үйлдэл гаргасныг “*Шивээн толгойгоор хөлөө хатгаж өвтгөн өвдөлтөө ч тоохгүй улам хатгах, тэгснээ цэцэг зулгаан зулж, түүнээ авч амандаа зажлан ногоон шүүс бултайлган ишиг болчих юмсан тэгвэл аавынх нь дагуулж ирсэн эмэгтэй миний охин гэхгүй дээ*” зэргээр дүрсэлсэн нь охины сэтгэл санаанд гарсан цочирдол, цочир өөрчлөлтүүд охины сэтгэхүйн хачин гэмээр ийм үйлдлээр охины сэтгэл зүйн зөн совин, суурь архетипүүд илрэн буйг уг туужийн хэрэг явдлын уран сайхны шийдлүүд харуулах бөгөөд тэр хэрээр зохиолчийн ур чадварыг үнэлэх уншигчдын үнэлэмж харуулж байна.

⁵ Байгалсайхан С. (1998), “Уран дүрийн онолын лекцүүд”, Улаанбаатар, 15-р тал.

“Уран бүтээлч хүн өөрийн бүтээлд ямар нэгэн тодорхой зорилго, зорилтыг тавьж түүнийгээ хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааны нэгэн адил баримтыг бус харин уран дүрийг ашигладаг”⁶⁾ болохыг эл туужийн жаал охин, түүний орчин тойрон, хүрээлэн аж төрж буй хүмүүсийн зан чанар, сэтгэл санаа, тэдний төөрөг тавиланг хэрхэн өөрчдөг жам ёсонг эхээсээ хагацаж, эцэг нь эхийг нь таалал болсныг ч мэдээгүй мөртөө олон жилийн хойно гэрт шинэ эхнэр буюу өөр эмэгтэй дагуулан ирснээр охиноо амьдын хагацалд унагаж, хөгшин эмэг эхтэйгээ үүрд үлдэх “Өнчин охин”-ы гунигт дүрээр уншигчдад ёс суртахуун, хүн чанар, уй гашуу, гэрэл гэгээ, гэр бүлийн хариуцлага, хүний аж амьдралд тохиолдож болзошгүй хурц, эмзэг асуудлыг хам цогцоор хөндөн харуулж чаджээ.

Туужид хэдийгээр Хишгээгийн амьдралыг ихэвчлэн өгүүлэх боловч зохиолын гол дүр бол Дэлэгийн охин юм. Охин ээжийнхээ амьд ахуйд аавыгаа санаж нэг өнчирсөн бол ээжээсээ хагацаад дахин өнчирсөн нэгэн. Зохиолын эхэнд эхээс хагацсан охин эцгийнхээ хуриманд хэрэглэх усыг зөөж явахдаа голын усанд насан элсэн ээжийгээ хий харан санааширч:

- *Ээжээ та ир л дээ. Эсвэл намайг аваач*

- *Болохгүй, охин минь болдоггүй юм*

- *Тэгээд би яах юм бэ?*” хэмээн ээжтэйгээ хий сэтгэлээр ярилцаж, энэ үедээ голын усанд ганц дусал нулимс унагасан хийгээд “усанд хар нулимсаа дусаах нь муу ёр” хэмээн ээжийн захисныг мартуулчих вий гэж бодож буй нь сэтгэлд хуралдсан асар хүнд үхэл, хагацал, гэр бүл салалтын хүнд ачаа, ээжийнхээ захиасыг эцэгт дамжуулж, ингэснээр ээжийнхээ амьд ахуйдаа аавыг нь хүлээсэн сэтгэлийг давхар зовлон шаналалыг тээж яваа сэтгэлийн ертөнцийг чадварлаг нээсэн аж. Туужид сэтгэлзүйн дүр бүтээсэн өөр нэг сэдэл санаа /мотив/ нь уянга сэтгэлзүйн зохиолд түгээмэл ашигладаг субъектив хэлбэр буюу ёр билгийн чанартай зүйлсийг ч эв донжтой чадамгай ашигласан байна. Ер нь Д.Норовын туульсын бүтээлүүд юмс үзэгдлийн мөн чанарыг домогзүй, зүүд, ёр бэлгээр дамжуулан, жам ёсоор төсөөлөн тайлах нь урлагийн бүтээл туурвихад үлэмж өргөн хэрэглэдэг. Охин усанд цагаа оруулчихвал ээжийнх нь захиас мартагдана хэмээх бодол харваж буй нь монгол хүүхэд, монгол ахуйн элементүүд бөгөөд зан үйл, ёр бэлгийг нөхцөлдүүлсэн уран чадварыг илтгэж байна. Энэ нь сэтгэл шинжлэлийн үүднээс үзэх юм бол “**айдас**” юм.

Д.Норовын зохиолуудад хүн эхийгээ хайрлах нь ухамсар, оюун санаа биш төрөлхийн инстикт болохыг нотолж өгдөг. Иймээс охин ээжийнхээ үхэлтэй эвлэрч чадахгүй ээжийнхээ гэсэн болгоныг эрхэмлэж гагцхүү ээжийнхээ эцсийн захиас үгийг дамжуулж хэлэхийг туйлын зорилго болгосныг туужид өгүүлдэг.

Уран дүр нийтлэг, түгээмэл хийгээд тусгай, диалектик харьцаанд оршдог гэхүл “Өнчин охин”-ы дүр нь уран дүр хоорондын хэв шинжийн хувьд ижил хийгээд дүрслэх хэрэглүүр буюу адилтгах, зүйрлэх, харьцуулах уран маяг голлож, уран сайхны янз бүрийн уран маяг, чимэглэх аргыг бага ашиглан туужийн үйл явдлын бүхий л утга, агуулгаар хүүхэд, түүний төөрөг тавилан, хувь ноогдол, сэтгэл санааны өөрчлөлт, төлөвшил нь тэдний аз жаргал, баяр хөөр, гуниг зовлон нь томчууд, эцэг эх, гэр бүлийн асуудлаас шууд хамааралтай болох, гэр бүлийн гишүүдийн тус тусын үүрэг хариуцлага түүнээс улбаалдаг хүүхдийн хүмүүжил, сэтгэл зүйн болон хувь заяаны төөрөг тавилан, саад бэрхшээл, ямар ч зовлон зүдгүүр тохиолдох боломжтойг уншигчдад нээн харуулах

⁶⁾ Энхбаяр С. (2011), “Уран зохиолын онол”, Улаанбаатар, 118-р тал.

гэсэн зохиолчийн бүтээлд түгээмэл жам ёсон, хүмүүний ёс суртахуун, үзэл санаа, орчин нөхцлийн үүтгэл үндэс болдог зүй тогтлыг нээхэд зохиолч их анхаарсан байна.

Охин хэдий эхийгээ алдчихаад шаналан санааширч суухдаа нуурын ус руу үсэрчихмээр бодогдох хэдий ч бяцхан охин эмээгээ орхиж хагацалд унагахгүй тул өрөвдлөөр ухаажиж буй дүрийн сэтгэл зүйн хувирал өөрчлөлт, өсөлтийн логикийг олон талтай, чадварлаг шийдсэн ажээ.

Охин амьдралтай тэмцэлдэхийн хэрээр ээжийгээ өмөөрч, өөр эхнэр дагуулан ирэх эцгийг ойлгож чадахгүй зөрчилдөж буйг зохиолч, охины усанд явах замдаа ээжийнхээ амардаг ногоон дэрсний шилд хүрч амрах, тэгвэл л бүх зүйл болж бүтчих юм шиг бодож буй нь бяцхан охины сэтгэлзүйн зөрчлийн дээд туйл буюу ганцаардахын зовлон, хүч хүрэхгүйн зовлон, эрх мэдэл үгүйн зовлон, хүүхдийн гэнэн хонгор зан чанарын зовлонг *“Гагц тэр хайр нигүүлсэл өөрийг нь орхин одсоныг яс махандаа мэдэрч, төрсөн гэрт нь найр цэнгэл бялхан байхад охин үхэтлээ ганцаардаж ийнхүү ус зөөж явав. Одоо түүнд ганцхан хөгшин ээж л үлджээ. Гэвч баяр гуниг, хайр энэрлээр охиноо өлгийддөг байсан цэл залуу, орь хүслэнт ээжийг орлож чадна гэж үү дээ...”* зэрэглон дүрслэлд шингээжээ.

Сэтгэл зовнилоос үүдэлтэй ухамсарт бус зөн билэг, ялангуяа бага насны хүүхдэд хүчтэй илэрдэг онцлогийг охины ээжийгээ санан санааширч, иймэрхүү бодлоор хань хийж *“Сайхан цэнхэр дээлээ өмссөн ээжийн нь царай дахин санаанд нь буув. Энэ удаа ээж нь гэрийнхээ гадаа нөмгөн зогсож охиноо дуудаад инээмсэглэн хүлээж байх шиг... Ээжийгээ хараад л баймаар. Миний охин ээждээ ир! Өөр хэн ч ингээж инээж дуудаж чаддаггүй байлаа. Ээжийнх нь тэр дуун, тэр инээмсэглэл, тэр л харц нь ээж нь бүхий л бие цогцосоороо хайр мөрөөдөл энэрэл нигүүлслийн охь дээж байсныг охин одоо бүрэн ухаараагүй явав”* гэж хий юм харах, сэтгэлэгийг энгийн хэрнээ ээж, охин хоёрын дүр хоорондын холбоог өөр өөр орон зай /амьд ба үхсэн/, өөр өөр цаг хугацаа /ээжийнх нь амьд цаг, нас барснаас хойших/-наас нээн нэгтгэж өгснөөр уянга- сэтгэлзүйн дүрийн дотоод амьдралыг гайхалтай нээсэн юм. Иймээс сэтгэц задлагийн шинжлэх ухаанд хүүхэд насны үйл явдал, хий мөрөөдлийг нягт, нямбай судлах хэрэгтэйг олон сэтгэлзүйчид тэмдэглэжээ. Охины дүрээр үйл явдлыг нэхэж бодож байгаа нь ээж, охин хоёр өөр дүр мэт боловч угтаа эр нөхрөө, эцгээ хүлээсэн нэг л гол баатрын дүрийг төгс бүтээсэн мэт санагдуулдаг.

Зохиолч туужийн гол баатар охины дүрийг тодорхойлол зүйн аргаар хөрөгчилж тоочилгүй зохиолын үйл явдал нь бүхэлдээ “хүүхэд” баатрын уламжлалт бус өвөрмөц шинэ дүрийг бүтээжээ. Эхээс нь хойш хураалттай асан гэрээ “манай гэр” гэж охин боддог асан бол “Аавынх” гэж бодох, эмээгийнхээ гэрийг “Манайх” гэж боддог болж хувьсаж буй нь балчир бага хүүхдийн бодол хийгээд түүндээ нийцтэй үг хэллэгээр өгүүлж эс чадах ч харцаараа илэрхийлж буйг /түүнийг унших/: *“Дэлэг эргэж хараад бяцхан охиныхоо үзэн ядсан аймшигт харцыг үзэв. Хүүхдийн нүд ийм аймшигтай хурц болдгийг, ер нь хүүхдийн харц хичнээн цэвэр тунгалаг байдгийг Дэлэг анх удаа үзэв.”* гэх тодорхойлолтод хүрэх агшин бол зохиолчийн уран чадвар төдийгүй туужийн ур зүйн гол онцлог ололт, шийдэл эрэл юм.

Өнчин охинд эцгийнх нь шинэ эхнэр дагуулж ирсэн хийгээд хэзээ ч эвлэрч чадахгүй олон явдлуудтай зэрэгцэн охины эхээс хагацсан гүн гүнзгий уй гашуудал цагаашраагүй нөхцөл байдлын үед нь эцэг дагуулж ирсэн эхнэртээ ээжийнх нь ганц гоёл болох сайхан цэнхэр тэрлэгийг гэр зуур өмс хэмээн шидсэнээс охин тэвчиж чадалгүй *“Чи миний аав биш, мэдэв үү”* хэмээн хэлэх аж. Туужийн төгсгөлд аавыгаа эхнэрээ дагуулан буцахад

охин ээжийнхээ амь тавихын өмнө “Мөн их хүлээсэн дээ” гэж эцэгт нь дамжуулсан үгийг хэлснээр зохиолынхоо бүх утга хэрэг явдлыг хураангуйлж эх, охин хоёрын эр нөхөр, эцгээ хүлээсээр нэг нь хорвоог орхин, нөгөөн өнчирч үлдсэн өр эмтрэм дүрийн зан төрхийг улмаа тодотгожээ.

Дүгнэлт: Энэхүү зургаан настай охины дүрээр амьдралын оршин буй сэрэл, бадрал, баяр хөөр, гутрал гуниг, бадрал, өшөө хорсол, ганцаардал, жигшил зэвүүцэл, айдсын тусламжтайгаар сэтгэн, тааламжтай хийгээд тааламжгүйг мэдрэн түүгээрээ дамжуулан ертөнцийг сайн, муугийн мөн чанарыг мэдэрч эхлэх “Өнчин охин”-ы тухай өгүүлсэн уянгын сэтгэлзүйн дүр бөгөөд туужид үүнийг өнгөрсөн ба одоо цагийн үйл явдлуудыг зэрэгцүүлж хураангуйлан зохиомжлон нэг талаас ээжийнхээ өргөдөг байсан хоёр том агроутай усыг дааж ядан барьж гар, мөрөө өвтгөх бие махбодынх нь зовлон, **амьдралын ачаа**, ээжийгээ алдаад удалгүй аавыгаа хүнийх болсныг мэдээд ээжийгээ улам бүр санах **сэтгэлийн ачааг** “Ус даахгүй бяцхан охин”, “Уй гашуугаа дийлэхгүй “Өнчин охин”-ы дүрслэлээр гайхалтай хослуулан дүрсэлж дээрх зөрчлийг хураан гаргаснаараа монгол туужийн уянга-сэтгэлзүйн эрэлд шинэ дүр болж чаджээ.

НОМ ЗҮЙ

1. Байгалсайхан С. (1998), “Уран дүрийн онолын лекцүүд”, Уб
2. Байгалсайхан С. (2014), “ХХ зуун тууж судлал”, Уб
3. Галбаатар Д. (2012), “Уран зохиол: онол, түүх, шүүмж”, Уб
4. “Монголын уран зохиолын дээжис”, (2007) 86 дугаар боть, Уб
5. “Монголын орчин үеийн уран зохиолын түүх IY боть”, (2014), ШУС, ХЗХ.
6. Энхбаяр С. (2011), “Уран зохиолын онол”, Улаанбаатар.
7. Юнг.К.Г. (2011), “Бэлгэдэлт амьдрал”, Улаанбаатар.

SUMMARY

The six-year-old girl in the novel represents the lyrical and psychological character that is an orphan feeling the essence of the good and bad of the universe transferring through positive and negative sensation by the help of life sense, inspiration, happiness, sorrow, revenge, loneliness, disgust and fear. They are described by contrasting and abridging the past and present plots, as **life burden** or body pain caused by barely lifting two huge wooden tubs of water on her shoulders which her mother used to carry and **burden on the mind** caused by increasingly missing her mother known that her father has an affair with another woman shortly after her mother's death. This character develops into a new character in the Mongolian lyrical-psychological novel by amazingly combining the descriptions of “A little girl barely carrying the water” and “An orphan girl hardly tolerating her sorrow”.